

“ТҮШИГ-УУЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 03 дугаар
сарын 20 -ны өдөр

Дугаар 22/02

Дархан-Уул аймаг

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компаний тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 ,Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14- ны өдрийн хурлаар баталсан Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын 2.6 дах заалтыг тус тус үндэслэн ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04 дүгээр сарын 29-ны 15.00 цагт Дархан-Уул аймгийн 3-р багт байрлах “Түшиг-Уул” ХК-ний өөрийн байрны хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:
 1. 2021 оны жилийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 04 дугаар сарын 11-ний өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2022 оны 03 дүгээр сарын 25-ноос эхлэн нийтлэх, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой дараах бичиг баримтуудыг “Түшиг-Уул” ХК-ийн төв байр болон хувьцаа эзэмшигчдэд үйлчилдэг БДК дээр бэлэн байлгаж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдэд хурал хуралдахаас өмнө танилцуулах ажлыг зохион байгуулсугай. Үүнд:
 - 1.1. Компанийн 2021 оны жилийн санхүүгийн тайлан, аудиторын дүгнэлтийн хамт
 - 1.2. Хурлаас гарах шийдвэрийн төсөл.
6. Хурлын санал хураах хуудасны загварыг Хавсралт 1-ээр баталсугай.
7. Санал хураах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг хурал хуралдах өдрийн буюу 2022 оны 04 дүгээр сарын 29 -ны өдрийн 17 цагаар тогтоосугай.
8. Хурлыг Гүйцэтгэх захирал г Ж.Батсайхан даргалахаар тогтоосугай.
9. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хурал зохион байгуулах тооллогын комиссын дарга, гишүүдийг Хавсралт 2-оор баталсугай.

ТУЗ-ийн дарга Ж.Баяраа



Санхүүгийн зохицуулах хорооны
 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн
 377 дугаар тогтоолоор баталсан
 "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн
 хурлын зар хүргэх журам"-ын нэгдүгээр хавсралт



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	" ТҮШИГ-УУЛ" ХК
Хаяг:	Дархан Уул аймаг Дархан сум 3-р баг
Хурал хуралдах өдөр, цаг:	2022 оны 4 дүгээр сарын 29
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Дархан Уул аймаг Дархан сум 3-р баг өөрийн байранд
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	ТУЗ
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2022 оны 3 дүгээр сарын 20
Олон нийтэд зарлах огноо:	2022 оны 3 дугаар сарын 25
Бүртгэлийн өдөр:	2022 оны 4 дүгээр сарын 11
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2022 оны 3 дугаар сарын 30
Хүргүүлсэн огноо:	2022 оны 3 дугаар сарын 30
Хурлын даргын нэр:	Ж.Батсайхан
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Б.Эрдэнэтуяа, Г.Энхтуяа, Б.Баярсайхан
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	
Баримт бичгийн хуудасны тоо: ширхэг
 хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА

..... /Б.Эрдэнэтуяа /
 2022 оны 3 дүгээр сарын 20-ны өдөр